



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/02

Хэрлэнбаян-Улаан тосгон

Үндсэн хөрөнгөнд бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 14 дүгээр зүйлийн 4, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан Canon GX6070 принтер-1ш, Цаас устгагч-2ш, ASUS i5 notebook-1ш, DELL 3530 i7 notebook-2ш, EPSON D5535 сканнер-1ш, хяналтын камер /иж бүрэн/-1ш, нийт 13277000 төгрөгний өртөг бүхий техник хэрэгслийг үндсэн хөрөнгийн дансанд тусгасугай.

2. Дээрх таван нэр төрлийн долоон ширхэг нийт 13277000 (арван гурван сая хоёр зуун далан долоон мянган) төгрөгийн өртөгтэй хөрөнгийг данс бүртгэлд оруулж тайлан балансдаа тусган ажиллахыг нягтлан бодогч (Ю.Батбаяр), нярав (Н.Ганцэцэг) нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ОТГОНБАЯР

